



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 90

Эрдэнэт

Ээлжит II хуралдаанаар хэлэлцэх асуудалд  
өөрчлөлт оруулах тухай

Аймгийн Засаг дарга, ерөнхий Аудиторын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Ээлжит II хуралдаанаар хэлэлцэх асуудалд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай асуудлыг хасах

1.2. Аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай асуудлыг нэмэх

1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, 2015 оны төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан тус тус аудитын дүнг нэмэх

1.4. Аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын дүнг аймгийн 2015 оны төсвийн гүйцэтгэлтэй хамтатган оруулж хэлэлцүүлэх

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА